



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар A/19

Арвайхээр

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай


Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 14 дүгээр зүйлийн 14.1.4, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07/05 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.2.4, 3.6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Гамшигаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх үүргээ зөрчиж архи, согтууруулах ундаа худалдаалсан Тарагт сумын 3 дугаар багт үйл ажиллагаа явуулж буй 3.Солонго эзэмшигчтэй “Өлзийт” хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий зөрчил гаргасан дээрх худалдааны газарт хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа О.Ганбат), Тарагт сумын Засаг дарга (Т.Нямдаваа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100048